

**“ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ ГЕОЛОГИ, УУЛ
УУРХАЙН КОМПАНИУДЫГ ДАГАСАН МОНГОЛ ДАХЬ
БИЗНЕСИЙН ХӨГЖИЛ”
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

ГҮЙЦЭТГЭГЧ: “ЭХЛЭЛ ХӨГЖИЛ” ТББ

**УЛААНБААТАР ХОТ
2005 ОН**

Гарчиг

A/ Судалгааны тухай	3 - 4
Б/ ГХОГУУК-тай хамтарч ажил, үйлчилгээ, бизнес эрхэлж буй Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллага, компаниудын дунд явуулсан санал асуулгын тайлан	6-14
В/ Олон нийт иргэдийн дунд явуулсан санал асуулгын тайлан..	14-22
Г/ Байгууллагын тухай	22

А. Судалгааны тухай

1. Оршил

“Гадаадын хөрөнгө оруулалттай геологи, уул уурхайн компаниудыг дагасан Монгол дахь бизнесийн хөгжил” сэдэвт судалгааг “Эхлэл Хөгжил” ТББ-ын судлаачид 2005 оны 10, 11 сард Улаанбаатар хотод явууллаа.

Энхүү судалгааг хийхдээ аль нэгэн байгууллага, хувь хүний эрх ашгийг хамгаалах болон хөндөх зорилгоор бус, Геологи уул уурхайн салбарын өнөөгийн нөхцөл байдалд хөндлөнгийн байгууллагын зүгээс бодит дүгнэлт өгч, асуудалд тодорхой, шударга байр сууринаас хандахыг эрмэлзсэн болно.

2. Судалгааны үндэслэл

Судалгаа хийх үндэслэлийг доорх байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Сүүлийн жилүүдэд Монгол Улсад уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байна. Монгол Улсад ашигт малтмалын томоохон ордууд нээгдэж, дэлхийн зах зээл дээр ашигт малтмалын үнэ өсөхийн хэрээр дэлхийд нэр хүндтэй томоохон геологи, уул уурхайн компаниуд, энэ чиглэлийн бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдын Монголыг сонирхох сонирхол улам ихээр нэмэгдэж байна.
2. 1997 оны “Ашигт малтмалын тухай хууль” болон бусад хууль эрх зүйн таатай орчин, нөхцөл болон дээр дурьдагдсан хүчин зүйлсийн улмаас Монгол Улсад өнөөдөр уул уурхайн жижиг компаниудаас эхлээд дэлхийд нэр хүндтэй олон компаниуд өөрсдийн салбар, төлөөлөгчдийн газруудаа нээж эхлээд байгаа төдийгүй зарим нь хайгуул хийх, орд ашиглах үйл ажиллагаандаа аль хэдийн ороод байна.
3. Гэвч сүүлийн жил гаруй хугацаанд Уул уурхайн салбар тэр дундаа томоохон нөөц бүхий орд газрууд, тэдгээрт хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай компаниудыг тойрсон эерэг, сөрөг мэдээ мэдээлэл, маргаан мэтгэлцээнүүд төр засаг, улс төрчид, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сонин, радио, телевиз, жирийн иргэдийн дунд хуурай өвсний түймэр мэт газар авч, сайнаасаа саар, муу мэдээлэл нь нэлээд жин дарж байна.
4. Дээрх нөхцөл байдлуудтай холбоотой зарим улс төрчдийн санаачлагаар “Ашигт малтмалын тухай хууль”-д өөрчлөлт оруулах хуулийн төсөл УИХ-д өргөн баригдаад хэлэлцэх хугацаагаа хүлээж байна.
5. Ашигт малтмалын тухай хуулийн өөрчлөлт, татварын бодлогын шинэтгэл, лиценз олголт, түүний төлбөр гэх мэт олон асуудлуудыг Монгол Улсын төр, засаг хэрхэн шийдэх шийдлийн хариуг гадаадын хөрөнгө оруулалттай томоохон уул уурхайн компаниуд, хөрөнгө оруулагчдын зүгээс маш анхааралтай ажиглаж байгаа тухай мэдээлэл ч нийгэмд тархаад байна.

6. Энэ бүх зэрэг, сөрөг мэдээ, мэдээлэлүүд нь Монголын ард түмэнд үнэн бодитой, итгэл үнэмшилтэй сонсогдохоосоо илүүтэй гайхсан, эргэлзсэн, итгэл алдарсан, туйлширсан, талцаж улс төржсөн, айн түгшиж, санаа зовоосон өнгө аясыг бүрдүүлж байна.

Эдгээр нөхцөл байдлуудаас үндэслэн Монгол улсын уул уурхайн салбарын өнөөгийн бодит нөхцөл байдал, дүр төрхийг тодорхойлохуйц судалгаа хийх зайлшгүй шаардлага байна гэж үзсэн болно. Улмаар судалгааны бодит үр дүнд үндэслэн уул уурхайн салбарт тулгамдаад байгаа олон асуудлуудыг цаг алдалгүй шийдвэрлэх, ард иргэд, төр засаг, улс төрчид, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдад бодит мэдээллийг хүргэх замаар тэднийг зөв шийдвэр гаргахад нь туслах, нөлөөлөх бололцоо нээгдэх боломжтой гэж үзэж байна.

3. Судалгааны зорилго, зорилт

Судалгааны баг уул уурхайн салбарыг тойрсон дээрх олон тулгамдсан асуудлуудаас эн тэргүүнд Монгол Улс дахь ГХОГУУК¹-уудыг дагасан бизнес, түүний хөгжлийн хэтийн төлөв байдал, үр ашиг, ач холбогдлыг тодорхойлох зорилго тавьсан.

Дээрх үндсэн зорилгоо хангах хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлсэн ба тэдгээр нь энэхүү судалгааны судлагдахуун нь болно. Үүнд нь:

1. ГХОГУУК-уудыг дагаж манай ард иргэд, байгууллага, компани, аж ахуйн нэгжүүдэд ямар ямар ажил, үйлчилгээ, бизнесийн шинэ боломжууд нээгдэж байгааг тодорхойлох.
2. Энэ боломжийг манай иргэд, компаниуд хэрхэн ашиглаж ажил, үйлчилгээ, бизнесийнхээ цар хүрээ, ашиг орлогоо нэмэгдүүлж байгааг тодорхойлох.
3. Эдгээр ажил, үйлчилгээ, бизнест иргэд, компаниуд хэр сэтгэл ханамжтай буйг тодорхойлох.
4. Цаашид энэ төрлийн ажил, үйлчилгээ, бизнесийн хамрах цар хүрээ хэрхэн өргөжих боломжтойг тодорхойлох.
5. ГХОГУУК-уудыг дагасан бизнесийн хөгжлийн цаашдын төлөв байдлыг тодорхойлох, санал зөвлөмж боловсруулах.

4. Судалгааны мэдээлэл цуглуулалт

Нийгмийн судалгааны практикт өргөн хэрэглэгддэг анкетын аргаар судалгааны үндсэн мэдээллийг цуглуулсан болно. Судалгаанд хоёр төрлийн анкетын маягт ашигласан болно. Үүнд:

1. ГХОГУУК-уудтай хамтран ажил, үйлчилгээ, бизнес эрхэлж буй Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллага, компаниудын дунд анкетын судалгаа явуулсан. Үүнд, тухайн байгууллага, компанийн удирдах албан тушаалын захирал, менежерүүдийг хамруулсан.
2. Олон нийт, ард иргэдийн дунд мөн анкетын судалгаа явуулсан. Олон нийт, ард иргэд ГХОГУУК-уудын давуу тал, үр ашгийг хэрхэн харж, үнэлж байгааг тодорхойлох зорилгоор анкетын судалгааг

¹ ГХОГУУК-Гадаадын хөрөнгө оруулалттай геологи, уул уурхайн компани

“Гадаадын хөрөнгө оруулагчтай геологи, уул уурхайн компаниудыг дагасан Монгол дахь бизнесийн хөгжил” судалгааны тайлан

500 хүний түүвэртэйгээр явуулсан. Олон нийт, ард иргэдийн дунд явуулах судалгаанд аль болох нийгмийн янз бүрийн бүлгүүдийн тэгш төлөөллийг хамруулахыг зорьсон болно.

Б/ ГХОГУУК-тай хамтран ажил, үйлчилгээ, бизнес эрхэлж буй Монгол улсын аж ахуйн нэгж, байгууллага, компаниудын дунд явуулсан санал асуулгын үр дүнгээс

Судалгаанд нийт 26 байгууллага хамрагдсан болно. Эдгээр 26 байгууллага нь бүгдээрээ ГХОГУУК-уудтай хамтран ажиллаж, тэдэнд үйлчилгээ үзүүлдэг Монгол улсын дотоодын компаниуд юм. Судалгаанд оролцсон компаниуд, албан тушаалтнуудын нэрийг судалгааны тайланд дурьдахгүй байхаар, түүнчлэн ямар компани ямар төрлийн бизнес, ажил, үйлчилгээг ГХОГУУК-уудтай хамтарч явуулдаг талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайланд дурьдахгүй байхаар тохиролцсон тул ерөнхий байдлаар мэдээлж байна.

Судалгаанд дээрх 26 байгууллагыг төлөөлөн ерөнхий захирал болон дэд захирал, менежер, ерөнхий инженер гэх мэт удирдах албан тушаалтнууд оролцсон. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 30.8% нь ерөнхий захирал, 15.4% нь дэд захирал болон адилтгах албан тушаалтан, 53.7% нь менежер, ерөнхий инженер, мэргэжилтэнгүүд тус тус байсан.

Судалгаанд оролцсон нийт байгууллагуудын 3.8% нь 1990 оноос өмнө, 7.7% нь 1990-1995 онд, 26.9% нь 1996-2000 онд, 61.5% нь 2001-2005 онуудад тус тус байгуулагдсан байна. Үүнд энгийн дүгнэлт хийвэл, дээрхи компаниудын ихэнх нь ашигт малтмалын үнэ дэлхийн зах зээл дээр өссөн үе, түүнчлэн ГХОГУУК-ууд Монгол улсад олноор орж ирэхтэй зэрэгцэн байгуулагдсан байна.

Судалгаанд хамрагдсан байгууллага, компаниуд доод тал нь 2-3, дээд тал нь 30-40 орчим ГХОГУУК-уудтай хамтран ажиллаж, тэдэнд хамгийн багадаа 2-5 төрлийн ажил, үйлчилгээ үзүүлдэг болох нь судалгааны үр дүнгээр харагдсан.

Судалгаанд хамрагдсан байгууллагууд дараах ГХОГУУК-уудтай хамтран ажилладаг байна. Үүнд: Boroo gold, Ivanhoe Mines Mongolia, QGX Mongolia, Asia Gold Mongolia, Centerra Gold Mongolia, Erdene Mongol, Gurvan Gol, Solomon Resources, Tethys Mining, Japan Geofile, Altan Dornod Mongolia, East Asia Minerals, Erdes Holding, Falcon Bridge, Gem & Gold Mongolia, International Uranium Mongolia, Major Drilling, Tsairt mineral, AIDD, Ajnai hurd, BHP Billiton, CVRD Corporation, Datsan Treid, Golden East Mongolia, Rich Mongol, Rio Tinto, Taishir tosol, Xandu Mines, Orica Mongoli, Shoroon Ord, Tsakhir Exploration, UGL Enterprises, Zapady Mines, Land Drill, Mongollimet гэх мэт нийт 34 гадаадын хөрөнгө оруулалттай геологи, уул уурхайн компаниудыг нэрлэсэн байна.

Дээрх ГХОГУУК-уудад Монголын үндэсний компани, байгууллагууд ямар төрлийн ажил, үйлчилгээ үзүүлж, хамтран ажиллаж, бизнес эрхэлдэг нь манай судалгааны хамгийн сонирхол татсан асуудал байсан бөгөөд доорх төрлийн ажил, үйлчилгээнүүдийг үзүүлж, хамтран бизнес эрхэлдэг байна. Үүнд:

1. Геологи, уул уурхайн чиглэлээр:

- Геологи хайгуул,
- Геологийн зөвлөгөө,
- Геофизик хайгуул, судалгаа,
- Геологийн мэдээлэл түгээлт,

- Топографийн судалгаа,
 - Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл нийлүүлэх,
 - Тэсэлгээний үйлчилгээ,
 - Тэсрэх бодисын тээвэрлэлт,
 - Эрдсийн түүхий эдийн хими шинжилгээ,
 - Геологийн сорилт боловсруулалт,
 - Гүний өрөмдлөг,
 - Металл хайлж, цэвэршүүлэх,
- 2. Банк, санхүүгийн үйлчилгээний чиглэлээр:**
- Даатгалын үйлчилгээ,
 - Санхүүгийн зуучлал,
 - Банкны бүх төрлийн үйлчилгээ,
- 3. Хүнсний хангамжийн чиглэлээр:**
- Ундаа, цэвэр уснаас эхлээд талх, хиам, нарийн боов гэх мэт ажилтнуудын хоол хүнсний хангамж,
- 4. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр:**
- Интернет, мэдээллийн технологийн үйлчилгээ,
 - Байгууллагын дотоод сүлжээ,
 - Программ хангамж,
 - Засвар үйлчилгээ,
 - Сансрын холбоо,
 - Суурин болон хөдөлгөөнт холбооны үйлчилгээ,
 - Шуудангийн үйлчилгээ, хэвлэл захиалга,
- 5. Захиалгаар бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт, хангалт, худалдааны чиглэлээр:**
- Барилгын материал,
 - Техник, тоног төхөөрөмж,
 - Техник тоног төхөөрөмжийн сэлбэг, хэрэгсэл,
 - Компьютер, электрон техник хэрэгсэл,
 - Тавилга, эд хогшил,
 - Бичиг хэргийн материал,
 - Ажилтнуудын нормын хувцас, хэрэгсэл,
 - Хүнсний бараа бүтээгдэхүүн,
- 6. Эмнэлэг, эрүүл мэндийн үйлчилгээний чиглэлээр:**
- Дотоод, гадаад ажилтнуудын эрүүл мэндийн бүх төрлийн эмчилгээ, үйлчилгээ,
- 7. Тээврийн үйлчилгээний чиглэлээр:**
- Зорчигч тээвэр,
 - Ачаа тээвэр,
 - Төмөр замын тээвэр,
 - Агаарын тээвэр,
- 8. Зөвлөгөө өгөх үйлчилгээний чиглэлээр:**
- Хууль зүйн зөвлөгөө,

- Өмгөөлөл,
- Монгол дахь бизнесийн орчны зөвлөгөө,

9. Зочид буудлын чиглэлээр:

- Зочид төлөөлөгчид байрлах, буудаллах,
- Хүлээн авалт, уулзалт ярилцлага явуулах,
- Хурал цуглаан зохион байгуулах

10. Түрээсийн чиглэлээр:


- Албан байрны,
- Автомашины,
- Хүнд машин механизм, техник, тоног төхөөрөмж зэрэг

болно.

Ийнхүү ГХОГУУК-уудыг дагасан бизнес, ажил, үйлчилгээ Монгол Улсад нэлээд эрчимтэй хөгжиж эхлээд байгааг дээрхээс харж болохоор байна. Өөрөөр хэлбэл, ГХОГУУК-ууд өөрсдийн үйлдвэрлэл, геологи хайгуул, орд ашиглалтандаа шууд хөрөнгө оруулалт хийж, Монгол улсад төрөл бүрийн татвар, хураамж төлөхөөс гадна Монголын байгууллага, аж ахуйн нэгж, компаниудтай хамтран ажиллаж, зарим ажил үйлчилгээгээ тэднээр гүйцэтгүүлж, үндэсний үйлдвэрлэлд давхар хөрөнгө оруулалт хийж, бизнесийн орчинг бий болгож байна.

Бид судалгаагаараа эдгээр дотоодын байгууллага, компаниуд ГХОГУУК-уудтай хэрхэн харилцаа холбоо тогтоож, түншилсэнийг сонирхосон юм. Судалгаанд оролцогчдын хариулсан байдлаас үзвэл 38% нь ямар нэгэн бизнесийн түншлэл, ажил хэргийн уулзалтын үеэр, 35% нь ГХОГУУК-ууд өөрсдөө хандаж хүсэлт гаргасан, 19% нь төсөл боловсруулаад хандсан, 5% нь интернетээр, 3% нь тендерт ялах замуудаар тус тус харилцаа холбоо тогтоож, ажил, үйлчилгээ, бизнес эрхлэх болсон байна. /График 1-ийг үзнэ үү/.

График 1: ГХОГУУК-уудтай харилцаа холбоо тогтоосон арга замууд.



Эндээс ГХОГУУК-ууд Монголын компаниудад хандаж хүсэлт гаргасан байдалд дүгнэлт хийх нь зүйтэй санагдлаа. Учир нь дотоодын компаниудад ГХОГУУК-ууд хандаж, санал тавих байдал нь нэлээд өндөр буюу 35% байна. Харин дотоодын компаниудын зүгээс санаачлага гаргаж, төсөл боловсруулан хандах байдал дөнгөж 19%-тай байгаа нь чамлалттай үр дүн юм. Түүнчлэн, ГХОГУУК-ууд тендер зарлаж, хамтран ажиллах байгууллага, компани сонгодоггүй нь ажиглагдаж байна. Энэ нь Монголд аливаа ажил үйлчилгээг, нэн ялангуяа геологи, уул уурхайн чиглэлийн ажил үйлчилгээг өрсөлдөн гүйцэтгэх компаниуд тийм ч олон байдаггүйтэй холбоотой байх. Тиймээс ГХОГУУК-ууд байгаа цөөн тооны ганц, хоёр компаниудыг судалж үзээд аль боломжтойд нь ханддаг байж болох юм. Хэрвээ ийм нөхцөл байдал байгаа бол дотоодын компаниуд бизнес, ажил үйлчилгээний маш их боломжуудыг алддаг байж таарна. Өөрөөр хэлбэл, Монголд зарим ажил үйлчилгээ үзүүлдэг дотоодын компани байдаггүй, байсан ч ажил үйлчилгээ үзүүлэх чадвар сул, хэт жижиг байх тохиолдолд ГХОГУУК-ууд ажил үйлчилгээгээ гадаадын компаниудаар гүйцэтгүүлэхээс өөр аргагүй байж болох юм. Үүнийг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлага байна.

Харин бизнес түншлэл, ажил хэргийн уулзалтуудын үеэр харилцаа холбоо тогтоох нь хамгийн өндөр хувьтай буюу 38%-ийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд энэ салбарт үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын хурал цуглаан, уулзалт ярилцлага, үзэсгэлэн яармагууд олноор зохион байгуулагдах болсонтой холбоотойгоор дээрх үр дүн гарсан гэж дүгнэж байна. Үүнийг судалгаанд оролцсон зарим дотоодын компаниудын удирдлагууд нэлээд онцолж, иймэрхүү уулзалтууд хамтран ажиллагч түншүүдээ олоход чухал ач холбогдолтойг тэмдэглэж байсан. Тиймээс төр засаг, бодлого боловсруулагчид, холбогдох байгууллагууд иймэрхүү уулзалт, үзэсгэлэн яармагуудыг зохион байгуулж, дотоодын компаниудаа томоохон ГХОГУУК-уудад танилцуулж, тэдэнтэй хамтран ажиллах бололцоог нь хангаж өгч байх нь чухал ач холбогдолтой арга хэмжээ болох юм.

Судалгаанд оролцсон компаниудын 76.9% нь ГХОГУУК-уудтай хамтарч ажиллахаасаа өмнө одоогийн эрхэлж байгаа бизнес, ажил үйлчилгээгээ эрхэлж байсан бол 23.1% нь өмнө нь ийм төрлийн бизнес, ажил үйлчилгээ эрхэлж байгаагүй байна. Сонирхолтой нь одоогийн бизнес, ажил, үйлчилгээний чиглэлээр өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаагүй 6 компанийн 4 нь ГХОГУУК-уудад ажил үйлчилгээ үзүүлж, хамтран бизнес эрхлэх зорилгоор шинээр байгуулагдсан байна. Нэн ялангуяа, ГХОГУУК-уудад мэргэжлийн, өөрөөр хэлбэл геологи, уул уурхайн салбарын үйлчилгээ үзүүлдэг дотоодын компаниудын олонхи нь энэ салбарын хөрөнгө оруулалт Монгол улсад нэлээд газар авсан үетэй зэрэгцэн байгуулагдсан байна.


Судалгаанд хамрагдсан дотоодын компаниуд ГХОГУУК-уудтай хамтран ажиллаж байгаадаа нэлээд сэтгэл хангалуун байсан. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 84.6% нь ГХОГУУК-уудад ажил, үйлчилгээ үзүүлж, хамтран бизнес эрхлэх болсноор байгууллагын үйл ажиллагаа, бизнесийн цар хүрээ тэлэхэд маш их эерэг нөлөө үзүүлсэн гэсэн бол 15.4% нь ерөнхийдөө сайнаар нөлөөлсөн гэжээ. Түүнчлэн бизнесийн цар хүрээ нэмэгдэхээс гадна компанийн нэр хүнд, байр суурь, боловсон хүчний чадавхи дагаад өсч байгааг судалгаанд хамрагдсан компаниудын

“Гадаадын хөрөнгө оруулагчтай геологи, уул уурхайн компаниудыг дагасан Монгол дахь бизнесийн хөгжил” судалгааны тайлан

удирдлагууд тэмдэглэж байсан. Судалгаанд оролцогсад ГХОГУУК-уудад ажил үйлчилгээ үзүүлж, хамтарч бизнес эрхлэх болсноор компанийн чадавхи, бизнесийн цар хүрээ өмнөхөөсөө 5-60% нэмэгдсэн гэж үзэж байна.

Энэ хэмжээгээр тэдгээр байгууллагуудын улсын төсөвт төлөх татварын хэмжээ мөн нэмэгдсэн байна.

График 2. ГХОГУУК-уудтай хамтарч ажил, үйлчилгээ, бизнес эрхлэх болсноор улсад төлөх татварын хэмжээ нэмэгдсэн эсэх.




Нийт судалгаанд оролцсон компаниудын 88.5% нь ГХОГУУК-уудтай хамтарч ажил, үйлчилгээ, бизнес эрхлэх болсноор улсад төлөх татварын хувь хэмжээ өссөн гэсэн байна. Эдгээр татварын хэмжээ өссөн гэсэн хариулт өгсөн компаниудын 56.5% нь хэдий хэмжээгээр өссөнийг тодорхой хэлэх боломжгүй гэж хариулсан бол бусад нь 5-300 хувиар улсад төлөх татварын хэмжээ өссөн гэжээ. Үүнээс 12.3% нь 5-40 хувиар, 13% нь 50 хувиар, 17.3% нь 60-300 хувиар тус тус өссөн байна.

Судалгаанд оролцсон компаниудын бизнесийн цар хүрээ, улсад төлөх татварын хэмжээ өсөхтэй зэрэгцээд шинэ орон тоо бий болж, шинээр ажиллагсад авч улс орны хэмжээнд тулгамдсан асуудал болоод байгаа ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад бодитой хувь нэмэр оруулж байгаа нь судалгаагаар харагдсан. Нийт судалгаанд хамрагдсан компаниудын 50% нь ГХОГУУК-уудад ажил үйлчилгээ үзүүлж, хамтран бизнес эрхлэх болсноор шинэ орон тоо буй болж, шинээр ажиллагсад авч ажиллуулах болсон байна. Үүнд доод тал нь 5 хүн, дээд тал нь 100 хүн ажилд шинээр авч ажиллуулжээ. Эдгээр шинэ орон тоо буй болгож, ажилтан авсан компаниудад нийлбэр дүнгээр 300 гаруй хүн ажилд орсон байна.

Цаашид орон тоо буй болгож, шинэ ажилтан ажилд авах төлөвлөгөө байгаа юу? гэсэн асуултанд 73.1% нь тийм, 19.2% нь үгүй, 7.7% сайн мэдэхгүй байна гэж хариулсан байна. Эндээс харвал цаашид ч эдгээр компаниудын үйл ажиллагааны цар хүрээ өсөн нэмэгдэж, тэнд шинээр ажлын байр буй болж, улам олон хүн ажилтай болох бололцоо харагдаж байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Үүнийг ч судалгаанд оролцогч компаниудын удирдлагууд бүрэн баталгаажуулж, **Танай компани ГХОГУУК-уудад үзүүлж байгаа одоогийн ажил, үйлчилгээ бизнесийнхээ хэмжээ, цар хүрээг, цаашид өсгөн нэмэгдүүлэх**

бололцоог хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултанд доорх байдлаар хариулжээ. /График 3-ыг үзнэ үү./

График 3: ГХОГУУК-уудад үзүүлж байгаа одоогийн ажил, үйлчилгээ бизнесийнхээ хэмжээ, цар хүрээг, цаашид өсгөн нэмэгдүүлэх бололцоог үнэлсэн үнэлэмж



Цаашид Монгол улсад ГХОГУУК-уудыг даган хөгжих бизнесийн төрөл, хэлбэр, үйлчилгээний цар хүрээ хэр нэмэгдэх бололцоотой гэж Та бодож байна вэ? гэсэн асуултанд:

- 53.8% нь маш их нэмэгдэх бололцоо бий,
- 42.3% нь тодорхой хэмжээгээр нэмэгдэх бололцоо бий,
- 3.8% нь нэг их нэмэгдэхгүй байх гэсэн хариултуудыг тус тус өгчээ.

Энэ асуултыг улам гүнзгийрүүлэн, **ГХОГУУК-ууд Монголын уул уурхайн салбараас бусад салбарын бизнес, үйлдвэрлэл, үйлчилгээнд хэр хувь нэмэр оруулж чадах вэ?** гэсэн асуултыг судалгаанд оролцогч компаниудын удирдлагуудад тавихад:

- 57.8% нь маш их хувь нэмэр оруулна,
- 38.5% нь ер нь бага ч гэсэн хувь нэмэртэй,
- 3.8% нь нэг их сүйдтэй хувь нэмэр оруулахгүй гэж тус тус хариулжээ.

Түүнчлэн нийт судалгаанд оролцогчдын 88.5% нь ГХОГУУК-уудыг даган бий болж байгаа бизнес, ажил үйлчилгээнүүд нь Монголчуудын ахуй амьдралд эерэг үр дүнгээ өгнө гэдэгт бүрэн итгэлтэй байгаагаа илэрхийлсэн юм. Мөн **ГХОГУУК-ууд ирээдүйд Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн чадавхид хэр зэрэг хувь нэмэр оруулж чадна гэж Та бодож байна вэ?** гэсэн асуултанд: /График 4-ийг үзнэ үү/

График 4: ГХОГУУК-ууд ирээдүйд Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн чадавхид хэр зэрэг хувь нэмэр оруулж чадна гэж Та бодож байна вэ?




График 4-өөс харвал судалгаанд оролцогчдын дийлэнх нь ГХОГУУК нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөлөл буюу өөрчлөлт авч ирнэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн байна.

Нэгэнт бид судалгаагаараа ГХОГУУК-уудын асуудлыг хөндөж байгаа учраас тэднийг тойрсон элдэв хэл ам, таагүй мэдээллүүдийн талаарх судалгаанд оролцогчдын санал бодлыг мөн тандсан юм. Улс төрчид болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ард түмний дунд тархаад байгаа ГХОГУУК-уудын талаарх таагүй мэдээллийг судалгаанд оролцогчдын 11.5% нь олны яриа ортой, үнэн байх гэж хүлээн авч байсан бол 53.8% нь тэд сайн муу, янз бүр л байдаг байх, 34.6% нь энэ бол улс төрийн шоу, хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашгийн үүднээс хийгдэж байгаа зүйл хэмээн эсэргүүцэж байлаа.

Эцэст нь судалгаанд оролцогчдын судалгаагаар дэвшүүлэн тавьсан асуудалд хандаж байгаа хандлага, байр суурь, санал асуулгад хариулсан хариулт, судалгааны мэдээлэл цуглуулах явцдаа тэдэнтэй уулзаж ярилцаж байх үеийн ажиглалт зэргийг харьцуулан судлаачийн зүгээс дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Судалгаанд оролцогчид нь ГХОГУУК-уудтай хамтран ажиллаж, тэдний нөхцөл байдлыг сайтар ойлгож, мэдэрсэн хүмүүс байсан. Тэд бусдын үгэнд итгэж, толгойгоо эргүүлэн улс төржиж, худлаа ярьж, хоосон хардахаасаа илүүтэйгээр нөхцөл байдлыг бодитоор харахыг эрмэлзэж байсан.
2. Судалгаанд оролцогчид аливаа зүйлийн болохгүй, муу талыг дөвийлгөхөөсөө илүүтэйгээр болж байгаа, бүтэж байгаа зүйлсийг улам бүр цааш нь хөгжүүлж, сайн сайханд хүрэхийг эрмэлзэж байсан.
3. Судалгаанд оролцогчид ГХОГУУК-уудыг дагаад Монгол Улсад шууд болон шууд бус хөрөнгө оруулалтууд орж ирэн, тэднийг дагасан бизнес хөгжих боломжтойг бүрэн ойлгосон, үүндээ бүрэн төгс итгэлтэй байна.
4. ГХОГУУК-ууд нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд тодорхой хэмжээний түлхэц үзүүлж, улс оронд нүүрлээд байгаа ажилгүйдэл, ядуурлыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмэр оруулж чадна гэдэгт тэд итгэлтэй байна.

Мөн судалгаанд оролцогч компаниудын удирдлагуудтай уулзаж ярилцаж байхад тэдний санаа зовоосон асуудлууд цөөнгүй байгааг тэд

тэмдэглэн хэлж байсан юм. Тэдний санаа бодлыг доорх байдлаар нэгтгэн хүргэж байна. Үүнд:

- Дэлхийн зах зээл дээр ашигт малтмалын үнэ дээд цэгтээ хүртэл өсч байгаа энэ алтан үе удаан үргэлжлэхгүй бөгөөд тодорхой хугацааны дараа эргээд үнэ унахаас өмнө боломжийг дээд хэмжээгээр ашиглахгүй байгаад санаа зовинож байна. Хэт их улс төржиж, хэт их хардлага сэрдлэгэ, сенсааци дэгдээж, нийгэм, ард түмний санаа сэтгэлийг үймүүлж байна.
- Улс төр, бизнесийн бүлэглэлүүд геологи, уул уурхайн салбарт хэтэрхий хутгалдаж байна.
- ГХОГУУК-уудыг үл ойлгогдох, хүлээлтийн байдалд оруулж байна. Тэдний итгэл алдарчих вий дээ, Монголоос хөрөнгө оруулалтаа татчих вий дээ гэсэн болгоомжлол байна.
- Төр засаг геологи, уул уурхайн салбарынхаа талаар тогтвортой бодлого баримтлах.
- Татварын болон Ашигт малтмалын тухай хуулиуддаа болгоомжтой, сэтгэлийн хөдөлгөөнөөр бус бодит байдлыг судалж, эдийн засаг, санхүүгийн нарийн тооцоо дүгнэлтийн үндсэн дээр нухацтай хандаж, зөв өөрчлөлтийг хийх.
- ГХОГУУК-уудыг төдийгүй дотоодын компаниудаа жижиг гэлтгүй бодлогоор дэмжиж, ижил тэгш нөхцөл, хөнгөлөлт үзүүлж, төрийн бодлогыг ижил түвшинд хүргэмээр байна.

V/ Олон нийт иргэдийн дунд явуулсан санал асуулгын тайлан

1. Судалгаанд оролцогчдын ерөнхий дүр төрх.


Олон нийтийн асуулгыг Улаанбаатар хотод явуулсан бөгөөд нийт 500 гаруй хүнийг хамруулсан. Санал асуулгад оролцогчдын насны байдлыг авч үзвэл:

- 10% нь 20 хүртэл настай,
- 23.6% нь 21-25 настай,
- 22.4% нь 26-30 настай,
- 23.2% нь 31-40 настай,
- 14.2% нь 41-50 настай,
- 6.6% нь 51-ээс дээш настай хүмүүс хамрагджээ.

Харин хүйсийн хувьд 45.4% нь эрэгтэй, 54.6% нь эмэгтэйчүүд байна. Боловсролын хувьд:

- 53% нь дээд,
- 11% нь тусгай дунд,
- 31% нь бүрэн дунд,
- 4% нь бүрэн бус дунд,
- 1% нь бага боловсролтой хүмүүс хамрагдсан байна.

График 5: Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин.



Түүнчлэн, судалгаанд төрөл бүрийн мэргэжлийн салбарын янз бүрийн ажил, бизнес, үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүсийн төлөөлөл хамрагдсан нь судалгааны үр дүн, олон нийтийн санал бодлыг төлөөлөх чадварыг дээшлүүлж чадсан гэж үзэж байна. Судалгаанд оролцогчдын:

- 27% нь төрийн байгууллагад,
- 12.5% нь төрийн бус, олон нийтийн байгууллагад,
- 9.9% нь хувиараа аж ахуй, бизнес эрхэлдэг,
- 5.6% нь жижиг наймаа, арилжаа хийдэг,
- 15.5% нь хувийн компанид ажилладаг,
- 0.8% нь малчин,
- 19.9% нь оюутан,
- 1.4% нь тэтгэвэрт,
- 6.0% нь ажилгүй,
- 0.6% нь бусад салбарт ажилладаг хүмүүс хамрагджээ.

Энэ бүхнээс харвал манай судалгаа Улаанбаатар хотын хэмжээнд олон нийт, ард иргэдийг бүрэн төлөөлөх чадвартай судалгаа болж чадсан гэж судлаачдын зүгээс дүгнэж байна. Учир нь манай судалгаанд эрэгтэй, эмэгтэй, залуу, дунд, ахмад үе, боловсролтой, боловсролгүй, ажилтай, ажилгүй, оюутан, малчин гэх мэт нийгмийн бүх бүлгүүдийн төлөөлөл хамрагдсан байна. Ер нь аливаа ниймийн судалгаа тэр дундаа олон нийтийн дунд явуулж байгаа судалгаанд нийгэм, хүн ам зүйн тэгш төлөөллийг хамруулах нь хамгаас чухал байдаг.

2. Геологи, уул уурхайн салбарын өнөөгийн байдалд ОН-ийн хандах хандлага.

Судалгаанд оролцогчдоос бид хамгийн түрүүнд “**Монгол Улс газрын баялаг, ашигт малтмалаа олборлон хөгжих цаг ирсэн гэдэгтэй Та санал нийлэх үү?**” гэж асуусан юм. Судалгаанд оролцогчдын 84.6% нь үүнийг хүлээн зөвшөөрч **тийм** гэсэн хариул өгсөн бол, 14.4% нь **үгүй** гэжээ. Үүнийг нарийвчлан харвал:

Хүснэгт 1: Монгол Улс газрын баялаг, ашигт малтмалаа олборлон хөгжих цаг ирсэн гэдэгтэй санал нийлэх эсэх, насны бүлгээр:

Насны ангилал	Монгол Улс газрын баялаг, ашигт малтмалаа олборлон хөгжих цаг ирсэн гэдэгтэй Та санал нийлэх үү?		Бүгд
	Тийм	Үгүй	
20 хүртэл настай	78.0%	22.0%	100.0%
21-25 нас	92.2%	7.8%	100.0%
26-30 нас	86.4%	13.6%	100.0%
31-40 нас	84.5%	15.5%	100.0%
41-50 нас	79.7%	20.3%	100.0%
51-ээс дээш настай	87.1%	12.9%	100.0%
Бүгд	85.6%	14.4%	100.0%

Хүснэгт 1-ээс харвал насны бүлгүүдийн хооронд саналын эрс зөрүү харагдахгүй байна. Харин дээд боловсролтой хүмүүсийн бүлэгт Монгол Улс ашигт малтмалаа олборлон хөгжих цаг ирсэн гэдэгтэй санал нийлсэн хүмүүсийн хувь хэмжээ бусад боловсролын түвшингүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр байна. /Хүснэгт 2-ыг үзнэ үү/

Хүснэгт 2: Монгол Улс газрын баялаг, ашигт малтмалаа олборлон хөгжих цаг ирсэн гэдэгтэй санал нийлэх эсэх, боловсролын түвшингээр.

Боловсролын түвшин	Монгол улс газрын баялаг, ашигт малтмалаа олборлон хөгжих цаг ирсэн гэдэгтэй Та санал нийлэх үү?		Бүгд
	Тийм	Үгүй	
Дээд	88.0%	12.0%	100.0%
Тусгай дунд	82.0%	18.0%	100.0%
Бүрэн дунд	82.9%	17.1%	100.0%
Бүрэн бус дунд	78.9%	21.1%	100.0%
Бага/боловсролгүй	100.0%		100.0%
Total	85.5%	14.5%	100.0%

Ийнхүү судалгаанд оролцогчдын дийлэнх нь Монгол Улс ашигт малтмалаа олборлон хөгжих цаг ирсэн гэдэгтэй санал нэгдэж байна.

Харин “**Монгол улс геологи, уул уурхайн салбартаа түшиглэн өндөр хөгжилд хүрэх үү?**” гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын:

- 20.2% нь бүрэн итгэж байна,
- 45.9% нь ер нь итгэж байна,
- 25.7% нь нэг их итгэхгүй байна,
- 2.8% нь огт итгэхгүй байна,
- 5.4% нь мэдэхгүй гэжээ.

Эндээс харвал 65 орчим хувь нь ямар нэгэн байдлаар Монгол улс ирээдүйдээ геологи, уул уурхайн салбартаа түшиглэн **“өндөр хөгжилд хүрнэ”** гэдэгт итгэж байгаа нь харагдаж байна. Харин 25.7% нь **“нэг их итгэлтэй биш”** өөрөөр хэлбэл, эргэлзэнгүй байгаа байдал ажиглагдаж байна. Харин **“огт итгэхгүй”** гэж 2.8% нь хариулжээ. Энэ бүгдээс харвал манай ард иргэд, олон нийт уул уурхайн салбар нь **“Монгол улсын ирээдүйн хөгжилд сайн сайхан байдал авч ирнэ”** гэсэн итгэлээ тэглээ алдаагүй нь харагдаж байна. Харин бид Монгол улс уул уурхайн салбартаа түшиглэн өндөр хөгжилд хүрнэ гэдэгт итгэхгүй байгаа болон эргэлзэж буй хүмүүс яагаад итгэхгүй, эргэлзэж байгааг нь тодруулах зорилгоор дараах асуултыг асуусан юм. **Хэрвээ итгэлгүй байгаа бол үүнд тань ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?**

Үүнд:

Хүснэгт 3: Хэрвээ итгэлгүй байгаа бол үүнд тань ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?

	Хариултууд	Хувь
1	Геологи, уул уурхайн компаниуд байгаль орчныг сүйтгэж байгаа байдал	25.9
2	Монголын ашигт малтмал, баялагийг гадагшаа их хэмжээгээр ямарч татваргүй зөөж байгаа байдал	22.8
3	Монгол хүн газрынхаа баялагаас хувь хүртэж чадахгүй байгаа байдал	13.5
4	Геологи, уул уурхайн компаниуд орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулахгүй байгаа байдал	8.9
5	Улс төрчдийн таагүй яриа	7.5
6	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээ, мэдээллүүд	5.2
7	Геологи, уул уурхайн компаниуд болон нутгийн иргэдийн хоорондох тэмцэл	5.2
8	Геологи, уул уурхайн компаниудын зохисгүй үйлдлүүдийг өөрийн биеэр харж мэдэрсэн явдал	5.0
9	Геологи, уул уурхайн компаниуд улс, орон нутгийн аль ч төсөвт орлого оруулахгүй байгаа байдал	3.5
10	Уул уурхайн компанийн тухай ойр дотны хүмүүсийн таагүй яриа	1.5
11	Бусад.....	1.0

Хүснэгтээс харвал уул уурхайн салбар нь Монгол улсын хөгжилд бодитой хувь нэмэр оруулна гэдэгт итгэхгүй, эргэлзэж байгаа хүмүүс байгаль орчин их хэмжээгээр сүйрэлд орж байна, байгалийн баялаг ямарч татваргүйгээр түүхий байдлаараа гадагшаа их хэмжээгээр зөөгдөж байна, Монгол хүн газрынхаа баялагаас хувь хүртэж чадахгүй байна гэсэн ойлголттой байгаа нь харагдаж байна. Үүн дээр улс төрчид болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн нийгэмд түгээж буй мэдээллүүд, геологи, уул уурхайн компаниуд болон орон нутгийн иргэдийн хоорондын зөрчил гэх мэт хүчин зүйлсүүд нөлөөлж байгаа нь харагдаж байна. Гэхдээ ийм итгэл үнэмшил, ойлголттой хүмүүс судалгаанд оролцогчдын цөөнх байгаа гэдгийг дахин дурдъя.

Сүүлийн үед зарим улс төрчдийн яриа болон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай геологи, уул уурхайн компаниудын талаар таагүй мэдээллүүд ихээр цацагдах болсон

билээ. Үүнийг судалгаанд оролцогчдын 33.1% нь **“олны яриа ортой, үнэн”** гэж хүлээж авч байгаагаа илэрхийлсэн юм. Харин 53.5% нь **“үнэн худал, янз бүр байх, сайн ч компаниуд олон бий, муу ч компаниуд олон бий”** гэсэн бол 7.2% нь дээрх таагүй мэдээллүүдийг эрс няцааж, **“шал худлаа, энэ бол хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашгийн үүднээс хийгдэж байгаа зүйл”** гэжээ. Харин нийт судалгаанд оролцогчдын 6.2% нь энэ талаар **“сайн мэдэхгүй байна”** гэжээ. Эндээс харвал манай иргэд олон нийт аливаа мэдээллүүдэд нэлээд уян хатан, наанатай цаанатай хандаж байгаа ба юутай ч олонхи нь буюу 53.5% нь аливаа мэдээллийг сайн муу, талаас нь дүгнэн, цэгнэж ойлгохыг эрмэлзэж байна.

3. Геологи, уул уурхайн салбарыг дагасан бизнесийн талаарх олон нийтийн ойлголт төсөөлөл, хандлага.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 85.2% нь одоогийн эрхэлж байгаа ажил, бизнесээсээ өөр шинэ санаа олж, шинэ ажил, бизнес эрхэлж хувийн амьдрал, ахуй, нийгмийн байр сууриа дээшлүүлэх хүсэлтэй явдаг байна. Харин 14.8% нь ийм бодолгүй ажээ. Эдгээр шинэ бизнес эрхлэх бодолгүй байгаа хүмүүсийн 30.4% нь **“миний одоогийн эрхэлж байгаа ажил, бизнес надад хангалттай ашиг авчирдаг”** гэсэн байна. Гэтэл 4.3% нь **“надад бизнес эрхлэх наад захын мэдлэг боловсрол байхгүй,”** 20.3% нь **“би бизнест тохирох хүн биш,”** 44.9% нь **“надад бизнес эрхлэх хөрөнгө, санхүүгийн чадавхи байхгүй”** гэсэн идэвхигүй хариултуудыг өгчээ. Одоогийн ажил бизнестээ сэтгэл хангалуун байгаа гэж хариулсан дээрх 30.4% нь нийт судалгаанд оролцогчдын 4.2% болж байгаа юм. Эндээс манай судалгаанд оролцогчдын бараг 95 орчим хувьд нь ямар нэгэн байдлаар амьдрал ахуйгаа сайжруулах алхам хийж, ажил төрөл, бизнесээ өргөжүүлэх хэрэгцээ шаардлага байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Түүнчлэн судалгаанд оролцогчдын 38.3% нь **“Монгол шинэ төрлийн бизнесийн санаа, шинэ бизнес эрхлэх боломж бололцоо байна”** гэж үзсэн бол, 46.2% нь **“ийм бололцоо бага ч гэсэн байгаа байх”** гэж итгэл муутай хариулт өгчээ. Харин 8.3% нь **“ийм бололцоо огт байхгүй”** гэсэн бол, 7.3% нь **“мэдэхгүй”** гэсэн байна. Эндээс харвал манай иргэдийн олонхи нь амьдрал ахуйгаа хэрхэн дээшлүүлэх, хэрхэн ажил төрөл, бизнесээ өргөжүүлэх талаар ойлголтгүй, үүнд итгэл муутай хандаж явдаг байна.

“Та Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалттай томоохон геологи, уул уурхайн компаниудыг дагасан үйлчилгээний болон бусад төрлийн бизнес, үйл ажиллагаанууд байж болох талаар бодож байсан уу?” гэсэн асуултанд 13.1% нь **“энэ талаар мэднэ”** гэсэн бол, 59.5% нь **“энэ талаар бодож байсан гэхдээ сайн мэдэхгүй,”** 27.3% нь **“энэ талаар ямар ч ойлголтгүй яваа”** гэж хариулсан байна.

Эндээс дүгнэхэд манай иргэд, олон нийт гадаадын хөрөнгө оруулалттай томоохон геологи, уул уурхайн компаниудыг дагасан бизнес Монголд хөгжих боломж бололцоо байгааг олж харж чадахгүй байна. Иймээс холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, уул уурхайн компаниуд олон нийтэд зориулан үнэн бодит мэдээ, мэдээллүүдийг хүргэх, уул уурхайн бизнес нь асар том хөрөнгө оруулалтыг шаарддаг,

энэ асар их хөрөнгө оруулалтын нөмөр нөөлгөнд геологи, уул уурхайн салбарын болон салбарын бус маш олон төрлийн ажил, үйлчилгээ, бизнес дагаж хөгжих боломжтой байдаг, үүнд ардчилсан, зах зээлийн эдийн засгийн нийгэмд иргэд, байгууллагууд чөлөөтэй өрсөлдөн орж ирэх бүрэн бололцоотой байдаг гэдгийг ойлгуулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Хамгийн гол нь ГХОГУУК-ууд нь Монгол орны эрдэс баялгийг олборлон ашиглахдаа улсын төсөвт багагүй хэмжээний татвар төлөөс төлдөг, мөн тухайн үйл ажиллагаа явуулж байгаа улс орондоо урт удаан хугацаанд тогтвортой ажиллаж, дотоодын компани, аж ахуйн нэгж байгууллагуудаар зарим төрлийн ажил, үйлчилгээгээ гүйцэтгүүлэх замаар шууд болон шууд бус хөрөнгө оруулалтуудыг оруулж, ард түмний аж амьдрал, улс орны эдийн засаг, үйлдвэрлэлийг сэргээхэд эерэг нөлөөллүүдийг үзүүлдэг гэдгийг өргөн хэмжээнд сурталчилж таниулах шаардлагатай байна.

Төгсгөлд нь судалгаанд оролцогчдоосоо **“МУ-д урт удаан хугацаанд оршин үйл ажиллагаагаа явуулах гадаадын хөрөнгө оруулалттай геологи, уул уурхайн компаниуд тодорхой салбар, чиглэлүүдээр шууд болон шууд бус хөрөнгө оруулалт хийж, нийгмийн хөгжилд ямар бодитой хувь нэмэр оруулж чадах вэ, үүнд нь хэр итгэлтэй байна вэ?”** гэдгийг тандан доорх асуултыг асуусан юм. Энэ асуултанд хариулсан байдлыг авч үзвэл ажлын байр бий болгох, уул уурхайн салбарын судалгаа шинжилгээ, техник, технологийн шинэчлэлт, боловсон хүчний чадавхи дээшлэх, дэд бүтцийн хөгжил, улсын төсвийн орлого нэмэгдэх, эдийн засгийн ерөнхий байдал сайжирахад бодитой хувь нэмэр оруулж чадна хэмээн олонхи нь үзжээ. /хүснэгт 4-ийг үзнэ үү/

Хүснэгт 4: Монгол улсад урт удаан хугацаанд оршин үйл ажиллагаагаа явуулах гадаадын хөрөнгө оруулалт бүхий томоохон уул уурхайн компаниуд доорх чиглэлүүдээр шууд болон шууд бус хөрөнгө оруулалт хийж, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулна гэдэгт та хэр итгэлтэй байна вэ?

Дугаар	Асуултын нэр	Бодитой хувь нэмэр оруулж чадна	Зарим талаараа	Бодитой хувь нэмэр оруулж чадахгүй	Мэдэхгүй
1	Ажлын байр буй болгох замаар олон хүний нийгмийн асуудлыг шийдэж ядуурлыг бууруулахад	36.2%	47.0%	11.0%	5.7%
2	Бүс нутаг болон орон нутгийн хөгжилд түлхэц үзүүлэх,	27.7%	49.9%	11.0%	11.4%
3	Нийгмийн хамгаалал /боловсрол, эрүүл мэнд, хүүхэд, эмэгтэйчүүд, нийгмийн эмзэг бүлэг, ядуурал, ажилгүйдэл/-ын тогтолцоог сайжруулах, түүнд дэмжлэг үзүүлэхэд	16.5%	36.7%	29.2%	17.7%
4	Уул уурхайн салбарын сургалт, судалгаа шинжилгээнээс авахуулаад техник технологид эрс өөрчлөлт, шинэчлэлт хийгдэхэд	42.7%	32.4%	7.9%	17.0%

“Гадаадын хөрөнгө оруулалттай геологи, уул уурхайн компаниудыг дагасан Монгол дахь бизнесийн хөгжил” судалгааны тайлан

5	Уул уурхайн болон бусад холбогдох салбаруудын боловсон хүчний чадавхи дээшлэх	31.3%	41.7%	12.7	14.4%
6	Үндэсний үйлдвэрлэл, жижиг дунд бизнес, ажил үйлчилгээ гэх мэт уул уурхайн компаниудыг дагаж буй болох бусад бизнесийн салбаруудын хөгжилд	28.7%	44.4%	12.6%	14.4%
7	Дэд бүтцийн хөгжилд /Зам, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч гэх мэт/	34.9%	38.6%	13.8%	12.7%
8	Улс орны эдийн засгийн хөгжил, санхүүгийн чадавхи нэмэгдэхэд	31.7%	33.8%	15.1%	19.4%
9	Улсын төсвийн орлого, татварын хувь хэмжээнд	35.0%	35.4%	14.1%	15.5%
10	МУ-н нэр хүнд дэлхийн тавцанд өсөх, МУ олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхөд	23.0%	37.4%	18.6%	21.1%
11	МУ-н үндэсний аюулгүй байдлын баталгаа хангагдахад	8.1%	23.6%	38.7%	29.6%

Харин бүс нутаг, орон нутгийн хөгжил, нийгмийн хамгаалал, үндэсний үйлдвэрлэл сэргэх, Монгол улсын нэр хүнд олон улсад өсөх, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын баталгаа хангагдахад бодитой хувь нэмэр төдийлөн оруулж чадахгүй гэж судалгаанд оролцогчид үзжээ.

Эцэст нь олон нийтийн дунд явуулсан санал асуулгын үр дүнг нэгтгэн дүгнэвэл:

1. Судалгаанд оролцогчид буюу олон нийт уул уурхайн салбарын өнөөгийн байдалд тийм ч таагүй хандахгүй байна.
2. Олон нийт уул уурхайн салбарын талаарх сайн, муу мэдээллүүдийн зааг ялгааг олж харах, аль болох уян хатан, наанатай цаанатай хандахыг эрмэлзэж байна. Иймээс уул уурхайн салбарын тухай үнэн бодит мэдээллийг олон нийтэд хүргэх шаардлагатай байна.
3. Гэвч олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн дунд үүссэн уул уурхайн салбарын талаарх таагүй мэдээллүүд олон нийтийн санаа бодолд нөлөөлж, тэдэнд энэ салбарын талаарх таагүй сэтгэгдэл төрж эхлээд байна.
4. Байгаль орчны сүйрэл, уул уурхайн салбараас улсын төсөвт орж ирэх ашиг, мөнгөний хэмжээ, ард түмний амьдралд хэрхэн нөлөө үзүүлэх вэ, эрдэс баялагийг түүхийгээр нь харийн орон руу ачаад явчих вий гэсэн болгоомжлол ард иргэдийн санаа сэтгэлийг зовоож байна.
5. Иргэдийн амьжиргааны түвшин ерөнхий байдлаараа доогуур байна. Олон иргэд өнөөгийн ажил, бизнесээ өргөжүүлж илүү сайн сайхан амьдрахыг хүсч байгаа ч хэрхэн өөрчлөх, сайжруулахаа мэдэхгүй байна.
6. Иргэд, олон нийтэд уул уурхайн салбарын нийгэмд, ард иргэдийн амьжиргаанд, үйлдвэрлэл, бизнест, улс орны эдийн засгийн хөгжилд ямар ямар бодитой үр дүн, үр ашиг авч ирэх, түүнээс

иргэд хэрхэн ямар арга замаар хүртэж болох талаар бодит мэдээлэл, сурталчилгаа, таниулгыг хийх цаг болсон байна.

7. Хамгийн гол нь иргэд, олон нийт Монгол улс өнөөдөр ашигт малтмал, газрын баялгаа олборлон ашиглах замаар улс орноо хөгжүүлэх цаг нь болсон гэдэгтэй олонхоороо санал нийлж байна.

Г. Байгууллагын тухай

“Эхлэл Хөгжил” ТББ нь 2005 оны 09 сард шинэ тутам байгуулагдсан бөгөөд “Монгол улсын хөгжилд хувь нэмрээ оруулан, Нийгмийн бүтээн байгуулалтыг ҮНДЭСНИЙ хэмжээнд бэхжүүлэхийн төлөө” үйл ажиллагаа явуулах зорилготой, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

Тус байгууллага нь: ардчилал, иргэний эрх, эрх чөлөөг ханган хэрэгжүүлэхэд төр болон ард түмэнд дэмжлэг үзүүлэх, цаг үеийн тулгамдсан асуудлаар мэргэжлийн түвшний судалгаа хийн, дүгнэлт гаргах, төрийн бодлогод иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, бизнесийн болон нийгмийн асуудлаар зөвлөмж боловсруулах, хууль эрх зүйн болон бусад зөвлөгөө өгөх, Монголын залуу үеийн боловсролыг дээшлүүлэхэд анхаарч, тэдэнд дэмжлэг үзүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тус байгууллага нь байгуулагдсанаасаа хойшхи богинохон хугацаанд *“Гадаадын хөрөнгө оруулалттай геологи, уул уулхайн компаниудыг дагасан Монгол дахь бизнесийн хөгжил”*, *“Ардчилал 15 жил”*, Улаанбаатар хотын тулгамдсан асуудал болох *“Авто зам”* сэдэвт нийгмийн судалгаануудыг хийж гүйцэтгээд байна. Эдгээр судалгаануудыг “Эхлэл Хөгжил” ТББ нь өөрсдийн санхүүжилт боломж дээрээ тулгуурлан явуулсан бөгөөд улс орны өмнө тулгамдаад байгаа асуудлуудын дүр төрх, мөн чанарыг тодорхойлон гаргах, төр засаг, бодлого боловсруулагчид, улс төрчид, олон нийтийн анхаарлыг хандуулах, улмаар нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, улс орны хөгжлийн гарцыг тодорхойлоход хувь нэмэр оруулах зорилгоор дээрх судалгаануудыг хийж гүйцэтгэсэн болно.

Ингээд уншигчид та бүхэндээ *“Гадаадын хөрөнгө оруулалттай геологи, уул уулхайн компаниудыг дагасан Монгол дахь бизнесийн хөгжил”* сэдэвт судалгааныхаа тайланг толилуулж байна. Цаашид бид Монголын өнөөгийн нийгмийн өмнө тулгамдсан асуудлуудыг хөндсөн судалгааны тайлангуудаа ОНМХ-р дамжуулан олон түмэндээ хүргэж байх болно.

Энэхүү судалгаатай холбоотой санал, бодолоо бидэнтэй хуваалцахыг эрхэм уншигч та бүхнээс хүсч байна. Та бидэнтэй: extbb@yahoo.com е-мэйл болон 99172526 дугаарын утас, “**ЭХЛЭЛ ХӨГЖИЛ**” ТББ, Скайпост /Skypost/ Шуудан 46, Ш.Х-91, Улаанбаатар хот, Монгол Улс-гэсэн хаягаар тус тус харилцаж болно.

“Эхлэл хөгжил” ТББ та бүхий санал бодол, шүүмжлэлийг хүлээн авахдаа баяртай байх болно.

***Судалгааны тайлан бичсэн
социологч Б. Бат-Өлзий***